



БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ
ДАХЬ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын
тайлан

Аудитын код: ХӨА-2022/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
Мөрөн сум
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn
Бизкон аудит ХХК-ийн
Ахлах аудитор Ч.Мөнхбаяр
Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com
Аудитор: Л.Пунсал-орлом
Утас: 88908680 Цахим хаяг: punsaa73@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.11 № 01/67
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛИЙН УЛААН ТАЙГЫН
УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Ж.ТӨМӨРСҮХ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөлийн Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөлийн Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,578,965.43	86,868,497.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	11,951,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	11,951,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,627,965.43	86,868,497.64
354	Хангамжийн материал	73,577,965.43	71,950,497.64
35410	Бичиг хэргийн материал	843,950.80	532,910.80
35420	Аж ахуйн материал	12,714,060.00	12,682,761.65
35440	Түлш, шатах тослох материал	6,598,860.00	950,000.00
35470	Бусад хангамжийн материал	53,421,094.63	57,784,825.19
35600	Мал амьтад	9,050,000.00	14,918,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	953,381,158.32	1,189,681,371.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	953,381,158.32	1,189,681,371.40
392	Биет хөрөнгө	933,059,858.32	1,169,360,071.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	657,270,701.93	657,270,701.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,535,889.10	-46,908,646.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,196,943.50	508,028,358.99
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,050,798.29	-112,107,294.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	162,618,676.49	162,618,676.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-75,753,766.75	-108,940,179.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,868,240.14	87,868,240.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,039,399.68	-23,894,844.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,290,718.08	77,868,656.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,845,568.00	-32,483,598.19
39217	Ном	40,000.00	40,000.00
393	Биет бус хөрөнгө	20,321,300.00	20,321,300.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,321,300.00	20,321,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,047,960,123.75	1,276,549,869.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,047,960,123.75	1,276,549,869.04
51	Засгийн газрын хувь оролцоо	1,047,960,123.75	1,276,549,869.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	33,231,420.00	33,231,420.00
51101	Өмч: - төрийн	33,231,420.00	33,231,420.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,009,570,558.85	1,238,160,304.14
51210	Өмнөх үеийн үр дүн	1,009,570,558.85	1,009,570,558.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	228,589,745.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,158,144.90	5,158,144.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,047,960,123.75	1,276,549,869.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,314,787,539.26	917,337,874.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	726,047,110.26	367,906,731.44
120	Нийтлэг татварын бус орлого	726,047,110.26	367,906,731.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	726,047,110.26	367,906,731.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	1,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	14,763,476.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	709,983,634.26	366,906,731.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	588,740,429.00	549,431,143.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	558,658,800.00	535,328,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	558,658,800.00	535,328,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,081,629.00	14,102,243.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	5,192,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,951,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,130,629.00	8,910,243.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	676,978,309.18	688,748,129.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,978,309.18	688,748,129.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,437,392.74	643,149,016.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,109,423.00	374,790,071.00
210101	Үндсэн цалин	290,024,514.00	307,293,138.00
210102	Нэмэгдэл	54,729,709.00	46,746,833.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,355,200.00	20,750,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,691,842.56	49,019,459.00
210201	Тэтгэврийн даатгал	32,183,904.40	33,917,306.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,348,423.28	3,781,197.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,207,191.26	3,024,958.25
210204	Ажилгүйдлийн даатгал	723,075.98	754,181.34
210205	Эрүүл мэндийн даатгал	7,229,247.64	7,541,815.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,727,700.00	5,987,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,187,800.00	1,214,000.00
210302	Түлш, халаалт	4,399,100.00	4,639,200.00
210303	Цэвэр, бохир ус	140,800.00	134,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,351,969.00	31,316,905.74
210401	Бичиг хэрэг	976,850.00	1,009,040.00
210402	Тээвэр, шатахуун	11,016,969.00	16,486,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,571,710.00
210404	Ном, хэвлэл	40,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,687,550.00	4,247,690.00

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	00.00	8,002,345.74
2105	Нормативт зардал	120,000.00	214,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	214,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,597,900.00	176,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	768,800.00	72,300.00
210604	Урсгал засвар	1,829,100.00	104,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,867,000.00	2,479,500.00
210702	Дотоод албан томилолт	2,867,000.00	2,479,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,126,294.00	64,704,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,746,694.00	62,960,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,300.00	277,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,000.00	285,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	198,300.00	292,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,845,264.18	114,460,340.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	321,600.00	351,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,523,664.18	114,109,140.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,540,916.44	45,599,113.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,256,300.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,256,300.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,284,616.44	45,599,113.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,284,616.44	45,599,113.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	637,809,230.08	228,589,745.29
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,016,972.70	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	25,016,972.70	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-25,016,972.70	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	612,792,257.38	228,589,745.29

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	483,529,502.28	521,919,067.18
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	483,529,502.28	521,919,067.18
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-86,751,200.81	-86,751,200.81
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх	33,231,420.00	5,158,144.90	1,009,570,558.85	1,047,960,123.75

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,009,570,558.85	1,047,960,123.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,009,570,558.85	1,047,960,123.75
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	228,589,745.29	228,589,745.29
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,238,160,304.14	1,276,549,869.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	606,293,758.00	562,382,143.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,063,476.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,063,476.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,063,476.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,763,476.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	590,230,282.00	561,382,143.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	558,658,800.00	535,328,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	558,658,800.00	535,328,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,081,629.00	26,053,243.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	5,192,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,951,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,130,629.00	20,861,243.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,489,853.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,489,853.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	606,293,758.00	562,382,143.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	606,293,758.00	562,382,143.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,311,988.56	516,783,030.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,634,319.00	374,790,071.00
210101	Үндсэн цалин	290,549,410.00	307,293,138.00
210102	Нэмэгдэл	54,729,709.00	46,746,833.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,355,200.00	20,750,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,691,842.56	49,019,459.00

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	32,183,904.40	33,917,306.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,348,423.28	3,781,197.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,207,191.26	3,024,958.25
210204	Ажилгүйдлийн даатгал	723,075.98	754,181.34
210205	Эрүүл мэндийн даатгал	7,229,247.64	7,541,815.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,042,500.00	4,972,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,400,800.00	1,214,000.00
210302	Түлш, халаалт	3,486,900.00	3,624,200.00
210303	Цэвэр, бохир ус	154,800.00	134,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,249,559.00	17,225,900.00
210401	Бичиг хэрэг	494,600.00	563,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,506,359.00	11,178,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,571,710.00
210404	Ном, хэвлэл	40,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,578,000.00	3,911,690.00
2105	Нормативт зардал	184,100.00	184,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	184,100.00	184,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	370,300.00	370,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	370,300.00	370,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,867,000.00	2,479,500.00
210702	Дотоод албан томилолт	2,867,000.00	2,479,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,833,368.00	67,390,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,453,768.00	65,646,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,300.00	277,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,000.00	285,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	198,300.00	292,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	439,000.00	351,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	439,000.00	351,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,981,769.44	45,599,113.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,746,153.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,489,853.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,256,300.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,235,616.44	45,599,113.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,235,616.44	45,599,113.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	536,328,900.00	502,701,030.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	536,328,900.00	502,701,030.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536,328,900.00	502,701,030.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,025,300.00	374,790,071.00
210101	Үндсэн цалин	296,602,700.00	307,293,138.00
210102	Нэмэгдэл	94,067,400.00	46,746,833.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,355,200.00	20,750,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,408,500.00	49,019,459.00
210201	Тэтгэврийн даатгал	38,287,400.00	33,917,306.64
210202	Тэтгэмжийн даатгал	4,030,300.00	3,781,197.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,224,200.00	3,024,958.25
210204	Ажилгүйдлийн даатгал	806,100.00	754,181.34
210205	Эрүүл мэндийн даатгал	8,060,500.00	7,541,815.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,972,400.00	4,972,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,214,000.00	1,214,000.00
210302	Түлш, халаалт	3,624,200.00	3,624,200.00
210303	Цэвэр, бохир ус	134,200.00	134,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,225,900.00	17,225,900.00
210401	Бичиг хэрэг	563,900.00	563,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,178,600.00	11,178,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.00	1,571,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,947,400.00	3,911,690.00
2105	Нормативт зардал	184,100.00	184,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	184,100.00	184,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	370,300.00	370,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	370,300.00	370,300.00
2107	Томилот, зочны зардал	2,479,500.00	2,479,500.00
210702	Дотоод албан томилот	2,479,500.00	2,479,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,311,700.00	53,308,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,564,300.00	51,564,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	277,800.00	277,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,600.00	285,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91,600.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	292,400.00	292,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	351,200.00	351,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	351,200.00	351,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	536,328,900.00	502,701,030.00

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	535,328,900.00	501,701,030.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	535,328,900.00	501,701,030.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	43.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
620004	Гэрээт ажилтан	03.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,053,243.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,053,243.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,082,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,082,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,082,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,971,243.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	11,971,243.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,053,243.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,053,243.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,192,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,861,243.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

/ төгрөгөөр /

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалингийн зардал, өглөг, авлага, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон аудит компанийн Хөвсгөл аймаг дахь салбарт 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Дархадын хотгорын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, нэн ховор болон ховордсон биологийн төрөл, зүйлийг хайрлан хамгаалах, хүний нөлөөлөлд өртөөгүй үзэсгэлэнт байгаль, нутгийн иргэдийн ахуй амьдрал, аж төрөх хэв маяг, зан заншилд тулгуурласан байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлж орон нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг БОАЖ-ын сайдын эрхлэх хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БОАЖ-ын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11 өдрийн А/641 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь 2018 оны А/11 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 3 хүний

бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 8 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 676.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.4 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	11.9	00	-11.9
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	82.6	86.8	4.2
Үндсэн хөрөнгө	953.4	1,189.7	236.3
Нийт хөрөнгө	1,047.9	1,276.5	228.6
Өр төлбөр	00	00	00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,047.9	1,276.5	228.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,047.9	1,276.5	228.6

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.08.19-ны өдрийн А/156 тоот тушаал, БОАЖЯ-ны сайдын 2021.09.20-ны өдрийн А/283 тоот тушаалаар 42.6 сая төгрөгийн үнэтэй УАЗ-220695 маркийн фургон автомашиныг, мөн Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төслөөс 8 нэр төрлийн 307.8 сая төгрөгийн, нийт 350.4 сая төгрөгийн хөрөнгүүдийг орлого авсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгө акталж, устгаагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 551,8 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 19.9 сая төгрөгөөр бууруулж 531.9 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллага нь тайлант онд шаардлагатай зардлуудад 1 удаа 3.4 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлсэн зохицуулалт, тодотголыг хийлгэж санхүүжүүлэх эх үүсвэрийг 535.3 сая төгрөг болгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 536.3 сая төгрөгийн төсөв баталсан ба 535.3 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 1.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 501.7 сая төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 1.0 сая төгрөг, нийт 502.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 469,1 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 33.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 502.7 сая төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь цалингийн зардал 93.0 хувийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 90.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/

/сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал хөтөлбөр	536.3	502.7	33.6	93.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	484.8	451.9	32.9	95.7
80221	Гэрээт ажиллагсдын зардал	28.8	28.8	00	100
81701	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга	13.8	13.4	0.4	96.9

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хэмжээний зардал				
81703	Ургамал хамгаалах зардал	8.9	8.6	0.3	96.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 2 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр Дэлхийн байгаль хамгаалах сангаас 5.2 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.8 сая төгрөг, нийт 26.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр урсгал зардлуудад 14.1 сая төгрөгийг зарцуулж, 11.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/

/сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал хөтөлбөр	26.0	14.1	11.9	54.2
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	11.9	0.0	11.9	0
81701	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	14.1	14.1	0.0	100

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жилийн эцсээр харилцагч байгууллагуудтай гэрээгээ дүгнэж, тооцоо нийлсэн акт үйлдээгүйгээс нягтлан бодох бүртгэлд өр авлага бүрэн тусгагдахгүй байх магадлал өндөр байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын дарга Ж.Төмөрсүх нь 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргаар томилогдсон боловч оронд нь дарга томилогдоогүй учир нэг хүн хоёр тусгай хамгаалалттай газрын даргын үүрэг гүйцэтгэж байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулах мэдээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Шилэн дансанд байршуулах мэдээ

№	Мэдээ гаргах хугацаа	Мэдээний тоо			
		Мэдээлбэл зохих нийт мэдээ	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жилээр гаргах мэдээ	11	9	0	2
2	Хагас жилээр гаргах мэдээ	4	4	0	0
3	Улирал бүр гаргах мэдээ	4	4	0	0
4	Сар бүр гаргах мэдээ	36	33	3	0
5	Тухай бүрт гаргах мэдээ	96	93	3	0
НИЙТ ДҮН:		151	143	6	2

Шилэн дансыг шалгахад тайлант онд мэдээлэх 151 мэдээнээс хуулийн хугацаа болоогүй 2, хугацаандаа мэдээлсэн 143, хугацаа хоцорсон 6 мэдээ байна. Үүнд:

Тайлант онд сар бүр мэдээлэх “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”, “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” гэсэн 3 төрлийн мэдээнээс тайлант оны 1-р сарын 3 мэдээ, тухай бүр мэдээлэх “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэсэн 3 төрлийн мэдээнээс 1-р саруудын 3 мэдээ, нийт 6 мэдээ хугацаа хоцорч шилэн дансанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцорч байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 8.4 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 33.2 сая төгрөг байгаа ба 24.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.1 сая төгрөгийн алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант онд 1.1 сая төгрөгийн үнэтэй хорголжин тэжээлийг 1.0 сая төгрөгөөр дансны ангилал буруу орлого авсан, мөн 0.1 сая төгрөгийн шатахуун, 0.02 сая төгрөгийн үнэтэй багажийг бараа материал дансанд тус тус орлого аваагүй байна. Тайлант онд бараа материал данснаас акталсан 8 нэр төрлийн 8.0 сая төгрөгийг үнэ төлбөргүй гарсан зардлаар, нийт 9.1 сая төгрөгийн журналын бичилтийг тус тус залруулав.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тогтмол болон хангамж, бараа материалын зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэвэр бохир усны зардлаас 0.1 сая төгрөгийг БҮТЭЗ-ийн зардал руу, БҮТЭЗ-ийн зардлаас 3.8 сая төгрөгийг урсгал засварын зардал руу, нийт 3.9 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16

дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2."Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж байх.

2. **Өглөг, авлагатай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Жилийн эцсээр харилцагч байгууллагуудтай гэрээгээ дүгнэж, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсээр харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.

3. **Шилэн данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл байршуулсан дүнг хянаж үзэхэд нийт 151 мэдээлэл оруулахаас хугацаа хоцорсон 6 мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн хугацаанд шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



/Э.БАТ-ЭРДЭНЭ/ 2022.02.14

Огноо:

АХЛАХ АУДИТОР



/Д.ОТГОНБАЯР/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР



/Ч.МӨНХБАЯР/

Огноо: 2022.02.10

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР



/Л.ПУНСАЛ-ОРЛОМ/

Огноо: 2022.02.10.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/ Д	Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулг а		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		4	13.0	1	9.1	0	0	0	0	3	3.9